

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ
(Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар)

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалын 6 дугаар зүйлийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газар нь www.health.bo.gov.mn цахим хуудас ажиллуулан харьяа эрүүл мэндийн байгууллагууд болон ард иргэдийг мэдээ мэдээлэлээр тогтмол ханган ажиллаж байна. Тус цахим хуудсанд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтууд, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогогыг хэрэгжүүлэх “ дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ сургалт хөтөлбөрүүдийг байршуулан ажиллаж байна. Мөн shilen.gov.mn болон www.gov.mn сайтуудад байгууллагын холбогдох ил тод нээлттэй байх мэдээллэлийг оруулан ажиллаж байна.	100%
1.2	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор байгууллага тус бүр ажлын байрны зорилго, зорилт, үндсэн чиг үүрэг, байгууллагын доторх нэгж, тасгийн хаяг байршил, өргөдөл гомдол хүлээж авах ажил хариуцсан албан тушаалтны овог нэр, утасны дугаар зэргийг байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудас, Фэйсбукк Баян-Өлгий Эрүүл Мэндийн Газар хаяганд байршуулж, эдгээр хаягаар болон байгууллагын олон нийттэй харилцах 70722511 дугаартай утасаар ирсэн санал өргөдөл гомдолыг цаг тухайд нь шийдэвэрлэн хариу өгч ажиллаж байна.	100%
1.3	эдийн засаг, нийгмийн хөгжилийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн, үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт үнэлгээ хийх төлөвлөгөө гарган хуваарийн дагуу Нэгдсэн эмнэлэгт 2 удаа, 4 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төвд нийт 10 удаа хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 06/18227 тоот албан бичгийг хүрээнд Дэлүүн сумын эрүүл мэндийн төвийн зарим ажилтнуудын 2020, 2021, 2022 оны цалингийн тооцоолол хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дотоод аудит хийж, холбогдох байгууллагын мэргэжилтнүүдэд танилцуулж, зөвлөмж өгч ажилласан. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох судалгаа, материалуудыг гаргаж өгсөн. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024.04.01-ний өдрийн СХШ/16 тоот шалгалтын удирдамжийн дагуу байгууллагын 2022, 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын танилцуулгыг	100%

		албан бичгээр хүргүүлсэн. Шалгалтын танилцуулгыг бүрэн эхээр нь pdf файлаар шилэн дансанд байршуулсан болно.	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын 3 дугаар хавсралын хүснэгт 3.10 болон аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжаар батлагдсан журмын 9 дүгээр хавсралтын дагуу байгууллагын тайланг үнэлж, холбогдох тайлангийн хамт Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.	100%
1.5	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж, заасан хугацаанд Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.	100%
1.6	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг жилийн эхний хагаст хагас жилийн байдлаар, сүүлийн хагаст сар бүр гаргаж, Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлж байна.	100%
1.7	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар албаны цахим шуудангийн хаяг	Эрүүл мэндийн газрын бүтэц, зохион байгуулалтын дагуу ажилчдын овог нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, зурагыг хэлтэс тус бүрээр байрлуулж, ажиллаж байгаа хүний нөөцийн ил тод байдлыг хангасан. Өрөө болгонд албаны хариуцах утас байхгүй, зөвхөн даргын туслах албаны суурин утастай. Утасны дугаарыг байгууллагын цахим хуудасны нүүр хэсэг болон холбоо барих буланд байршуулсан.	100%
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудсын мэдээллийн ил тод цэсэд улирал тутам байршуулан ажиллаж байна. Тайлангийн жилд нийт 198 хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс иргэнээс 172, ажилтнаас 28 өргөдлийг хянан хариу өгсөн. Үүнээс шийдвэрлэсэн 186, судалж байгаа 12, шилжүүлсэн 15, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх явцад хугацаа хэтэрч хариу өгсөн 3 байна. Өргөдлийн агуулгыг авч үзвэл ажилд орох тухай, ажилтны хүсэлт нь чөлөө хүссэн, ажлаас чөлөөлөх, чөлөөний хугацаа дуусаад ажилдаа орох, тусламж, тэтгэмж хүссэн, тэтгэвэрт гарах хүсэлтүүд эзэлж байна. Өргөдлийг хянах, судлах ажиллагаанд хуулийн хүрээнд баримт, үндэслэл, холбогдох чиг үүргийн нэгжээс санал авах, хүсэлт гаргасан иргэнээс нягтлан тайлбар авах, удирдлагуудад танилцуулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, харъяалах нэгжээс санал авч хамтран судалж, шийдвэрлэж ажилласан.	100%

1.9	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Байгууллагын health.bo.gov.mn цахим хуудсын статистик мэдээ буланд аймгийн эрүүл мэндийн салбарын улирал бүрийн статистик мэдээллийг байрлуулж байна.	100%
1.10	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Төрийн болон төрийн бус байгууллагууд, ард иргэдэд чиглэсэн эрт илрүүлэг, халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх, стресс менежмент, эрүүл зөв хооллолт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ЖСА, цус багадалтын шалтгаан, Уур амьсгалын өөрчлөлт- Эрүүл мэнд” Хүнсний бүтээгдэхүүний шошго таньж мэдэх чиглэлээр сургалт явуулж, 60000 хүнийг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн 2-12 дугаар ангийн сурагчид МБС-ын оюутануудад эрүүл зөв хооллолт, эрүүл мэнд өглөөний цайнаас эхэлдэг, өсвөр насны онцлог, эрт илрүүлэгийн ач холбогдол, хүний папилома вирусийн эсрэг вакцин сэдэвт сургалтууд зохион байгуулж, 3258 хүүхдийг хамруулсан. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил 2024” нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 20 гаруй эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулж, тус тусдаа сэдвээр сургалт сурталчилгаа хийж ажилласан. сурталчилгаа явуулж, гарын авлага тараасан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар, салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүний папилома вирусийн халдварын эсрэг вакцины ач холбогдол, нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил, Улаанбурхан улаанууд өвчнөөс сэргийлэх, угаарын хийн хордлого, А аминдэм, ОНБТБэлдмэлийн ач холбогдол, эрүүл ахуйн шаардлага хангасан ариу цэврийн байгууламж, вируст гепатитээс сэргийлэх талаар гэдэсний халдвараас сэргийлэх, халдварт бус өвчин, эх нярайн нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр үеийн талаар нийт 60 удаа тус тус мэдээлэл хүргүүлсэн.	100%
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	“Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, тусгай шалгалт зарлуулах тухай захиалгыг” аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 удаа хүргүүлэн 2 ажлын байранд тусгай шалгалтыг зарлуулсан. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу тухайн албан тушаалд ажиллах тусгай шаардлагыг хангасан албан хаагчид шалгалт өгч тэнцсэн бөгөөд одоогоор Төрийн албаны салбар зөвлөлөөс	100%

		нэр дэвшүүлэх тогтоол ирүүлээгүй. Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалт, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын дагуу 5 албан хаагчтай харилцан тохиролцож газрын даргын тушаалаар эзгүй байгаа орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалтаар түр орлон гүйцэтгүүлж байгаа 2 томилгоог зөрчилтэй гэж зөвлөмж ирүүлсэн бөгөөд 2 албан хаагчийг хууль журмын дагуу чөлөөлж, тус зөрчлийг арилгасан.	
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ыг байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудасны Хүний нөөцийн ил тод байдал цэсэд байршуулсан. Ажилгүй байгаа эмч, мэргэжилтнүүдийг тухай бүр бүртгэн авч хувийн хэвшлийн болон өрх, сумын Эрүүл мэндийн төвөөс гарсан түр орон тоог санал болгон ажиллаж байгаа. Нэгдсэн эмнэлгийн хувьд ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг тус эмнэлгийн ерөнхий эмчийн 2021 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулан томилгоо хийсэн.	100%
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбоотой газрын даргын тушаалаар байгууллагын ёс зүйн багийн бүрэлдэхүүнийг шинээр байгуулж, багийн хурлыг 9 удаа хийж багийн ажиллах төлөвлөгөө, баримтлах дэг гэх мэт холбогдох эрх зүйн актаа батлуулж, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн ёс зүйн багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж өгсөн. Гомдлын дагуу Бугат, Алтай, Баяннуур сумын эрүүл мэндийн төвүүдэд очиж ажиллаж “Ёс зүй ба харилцаа хандлага” сэдвээр сургалт явуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн ЭМГ-ийн хамт олон, хувийн хэвшлийн эмнэлгүүд, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эм найруулагч нарт “Эерэг сэтгэлгээ ба хандлага”, “Ёс зүйн зөрчил юунаас үүсдэг вэ?” сэдвээр давхацсан тоогоор 150 орчим эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт “харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих”, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах”; 9.1.3 дахь хэсэгт “урьдчилан	100%

		сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах” чиг үүргийн хүрээнд Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн ёс зүйн дэд хорооны гишүүдэд нэг өдрийн сургалтыг зохион байгуулж, нийт 53 хамрагдсан. Албан хаагчдыг Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 2 удаа хамруулан ажилласан. Байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсэд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг тус тус байршуулсан. 2024 онд ЭМГ-ын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн нь ЭМСайдын 2017 оны А/256 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан дүрэм, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаал "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжилтийг тус тус ханган ажилласан бөгөөд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.	
2.4.	хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Байгууллагын хүний нөөцийн стратеги төлөвлөгөө болох “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” дэд хөтөлбөрийг 2023-2025 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хэрэгжилт 85 хувьтай. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 1012 дугаар захирамжаар батлагдсан “Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын журам”-ын дагуу үнэлгээ хийж ажилладаг.	100%
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар газрын www.health.bo.gov.mn цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр хийж байна. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн	100%

		мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог байгууллагын дотор болон харьяа байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд төсвийн зардал болон орон нутгийн зардлаар суралцах эмч, мэргэжилтнүүдийн захиалгыг салбар нэгжүүдээс авч хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу сургалтын захиалгыг өгч Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан суралцагчдын хяналтын тоо, бусад мэдээллийг салбар нэгжүүдэд хүргүүлэн, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдлын судалгааг гаргасан. Үүнд сум, тосгон ,өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 82 их эмчийн 54% буюу 43 , 159 сувилагчийн 37% буюу 61 сувилагч төгсөлтийн дараах мэргэшил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан бол Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмч нарын 98 буюу 91%, сувилагчдын 79 буюу 48% нь нарийн мэргэжилийн сургалтанд хамрагдсан тухай судалгаа гарсан. Цаашид төгсөлтийн дараах сургалтад анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжлтнүүдийг түлхүү хамруулах, НЭ-ийн эмч, сувилагч, тусгай мэргэжлтнүүдийг үе шаттай төрөлжсөн мэргэшлийн мэргэшүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд байршуулж, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ын дагуу үнэлэн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал болон улирлын урамшууллыг олгож байна. Нэгдсэн эмнэлгийн хувд “Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал” олгох тухай 05 дугаар тогтоолын дагуу эмч ажилчдын мэргэжлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журамтай. Тасаг бүр ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг тусгай шалгуур үзүүлэлтээр хүн тус бүрээр дүгнэн саналаа удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж албан хаагчдын ажлын үр дүнгээр үр дүнгийн урамшуулал олгодог.	100%
Хэсгийн дундаж хувь: 100%			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны талаар			

3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Эрүүл мэндийн газар нь 2023 онд 914,4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, 886,637,055 төгрөгийн буюу 97,0 %-ийн гүйцэтгэлтэй гарсан. 2024 оны 4258,1 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй. Үүний 2902,0 сая төгрөг нь салбарын хэмжээний Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 ба 29.5 дахь заалтуудаар авах тэтгэмжийн мөнгө болно. 2025 оны төсвийн төслийг боловсруулж Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст уламжилсан. Шилэн дансанд тухай бүрт нь мэдээлсэн.	100%
3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Эрүүл мэндийн газар нь 2024 оны хагас жилийн байдлаар 628,2 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 608,8 сая төгрөгийн буюу 96,9%-ийн гүйцэтгэлтэй гарсан. 2024 оны хагас жилийн байдлаар 15,1 сая төгрөгийн өртэй гарсан. 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг pdf файл хэлбэрээр шилэн дансанд байршуулсан. 2024 оны бүтэн жилийн санхүүгийн тайлан гарах хуулийн хугацаа болоогүй байгаа.	100%
3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Аймгийн Төрийн аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт авсан. Ямар нэгэн зөвлөмж, албан шаардлага өгөөгүй. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.	100%
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	хамааралгүй	-
3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Эрүүл мэндийн яаманд хүргүүлдэг. Мөн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний хэтрэлт, хэмнэлтийн тайлбарын хамт шилэн дансанд байршуулсан.	100%
3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	хамааралгүй	-
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн	Эрүүл мэндийн газрын 100020020001, 100020020401 тоот дансуудад 5,000,000 төгрөгөөс дээш орсон орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний	100%

	бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт сар болгон шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.	
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүссэн аливаа шийдвэр	2022 оны 02-р сард 3 төрлийн, 4-р сард 4 төрлийн, 5-р сард 2 төрлийн, 6-р сард 2 төрлийн, 7-р сард 2 төрлийн, 9-р сард 1 төрлийн, 10-р сард 2 төрлийн нийт 16 төрлийн байгууллагын даргын хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаалуудыг pdf файл хэлбэрээр шилэн дансанд байршуулсан.	100%
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлтөд буюу цаг тухайд нь хууль журмын дагуу байршуулсан эсэхт байнга хяналт тавьж ажиллаж байна. Энэ жилийн байдлаар 100% хөтөлөн ажиллаж байгаа боловч хугацаа хоцроосон алдаа дутагдал илэрсээр байна. Цаашид хугацаандаа оруулж хэвших талаар албан бичиг хүргүүлэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор сар болгоны эхэнд харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан нарт утсаар болон цахимаар сануулан, албан бичгээр шилэн данс хөтлөх талаарх заавар зөвлөмж өгч ажилладаг. Эрүүл мэндийн яамны 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/3030 дугаар албан тоотын дагуу манай харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, гарсан алдаа дутагдалын талаар Эрүүл мэндийн газрын даргын 553 тоот албан бичгээр зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажилласан. Аудитын байгууллагаас өгсөн акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж, цаашид зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, төлөвлөгөө гарган ажиллахыг үүрэг болгож ажиллав.	100%
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн	2024 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу зохион байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад урилга нийтэлж, тус тендерт оролцох эм ханган нийлүүлэх байгууллагуудад тендерийн	100%

	баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	материалын талаар тодруулга мэдээллийг ЭМГ-ын даргын 161, 162, 166, 177, 190 тоот бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад багц тус бүрээр Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлэн шалгаруулж, хууль тогтоомжийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан. Тендер шалгаруулалтын урилга, үр дүн, тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар оролцсон компаниудад албан бичгээр мэдэгдэж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг байгуулав. Тус тендерт 21 компани оролцож 15 компани шалгарав.	
3.11.	худалдан авах үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	2024 оны байдлаар худалдан авах үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалт үгүй.	100%
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил аргазүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	хамааралгүй	-
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	2023 оны тайлант жилд 14,607,300 төгрөгийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилттэй. Гүйцэтгэл нь 7,187,390 төгрөг.	70%
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	хамааралгүй	-
3.15.	хууль тогтоомжид заасан бусад	Эрүүл мэндийн салбартай холбоотой, нийтэд мэдээлэх зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг тухай бүрт байгууллагын цахим хуудас, Facebook пэйж хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж байна. Цахим хуудасны “Эрхзүйн актууд” буланд холбогдох хууль тогтоомж, аймагт хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүд, “Ил тод” булангаар байгууллагын шилэн дансыг тогтмол хөтөлж, санхүүгийн ил тод байдлын тайланг тухай бүрт байршуулдаг. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлт, цаг тухайд нь хууль	-

		журмын дагуу байршуулсан эсэхт байнга хяналт тавьж ажиллаж байна. ЭМЯ-ны санхүүжилттэй эрүүл мэндийн 6 байгууллагын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж, удаа дараа шаардаж бүрэн байршуулж, тайланг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлж байна.	
Хэсгийн дундаж хувь: 97%			
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны А/383 дугаар тушаал болон Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ний А/58 дугаар тушаалаар мөн Улсын мөнгөн тэмдэгтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлж байна. Мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулсан.	100%
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Эрүүл мэндийн сайдын А/100, А/383 тушаал, Эрүүл мэндийн газрын даргын А/58 дугаар тушаалуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй. 2024 онд Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүн 8 удаа хуралдаж, 6 эрүүл мэндийн байгууллага, 7 эмийн санд тус бүр 3 жилээр шинээр тусгай зөвшөөрөл олгосон, 8 сумын ЭМТ, 1 АНЭ, 2 ТТЭмнэлэг, 1 рашаан сувилал, 1 шүдний клиник, 1 ортой клиник, 8 эмийн сангийн тусгай зөвшөөрөлийн хугацааг тус бүрийг 5 жилээр сунгаж, 2 ЭМБ-ын тусгай зөвшөөрлийн эрхийг түдгэлзүүлж, 10 ЭМБ-ын тусгай зөвшөөрлийн эрхийг цуцалсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд ил тод тухай бүрт мэдээллэж байна.	100%
Хэсгийн дундаж хувь: 100%			
Тав. Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал			

5.1	олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	хамааралгүй	
5.2	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	хамааралгүй	
5.3	хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	хамааралгүй	
5.4	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Эрүүл мэндийн газар нь 2009 онд авсан 0210458 дугаартай, Өлгий сумын 4 дүгээр багт төрийн байгууллагын конторын зориулалттай 1500 м.кв талбайтай газрыг 50 жилийн хугацаанд эзэмших гэрчилгээтэй.	100%
5.5	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	хамааралгүй	
5.6	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүр: үүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн	хамааралгүй	

	этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулалтад оролцогчидын талаарх мэдээлэл		
5.7	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	хамааралгүй	
5.8	мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	хамааралгүй	
5.9	барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	хамааралгүй	
5.10	ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	хамааралгүй	
5.11	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт	хамааралгүй	

	тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлтэй өгөгдөл		
5.12	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг \эх\-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардал дүн, гэрээний хэрэгжилт	хамааралгүй	
5.13	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	хамааралгүй	
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хэрэгжилтийн дундаж хувь: 100%			

Нэгтгэсэн: ЭМГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн К.Жандаулет